

Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдал

ц. Базар*

• УИХ-ын ХМА, магистр

“Хэрвээ сэтгүүлчид авилгал, ядуурал, айдас болгоомжлолын нөхцөлд байгаа бол тэнд хэвлэлийн эрх чөлөө байхгүй”

(Брюссельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн холбооны баримт бичгээс)

Өнгөрсөн XX зуун хэвлэлийн эрх чөлөөний төлөө тасралтгүй тэмцлийн зуун байв. НҮБ, ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагын удирдлагууд “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үй түмээр нь зөрчсөн зуун” хэмээн дүгнэв. Басхүү “Шинэ мянганы хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь үржин төлжиж буй мэдээллийн нийгмийн үндэс, хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн хүч болохын хувьд өмнө нь хэзээ ч байгаагүй тийм их чухал ач холбогдолтой болж байна” хэмээн энэ зууны хэвлэл мэдээллийн үнэ цэнийг томъёолов. Мөн Токио хотноо 2001 онд болсон Дэлхийн хэвлэл мэдээллийн холбооны “Шинэ мянганы хэвлэл мэдээллийн нэгдмэл чиг хандлага” бага хурал “Дэлхий дахин ашиг хонжооны

төлөөх мэдээ, мэдээллээр дүүрч байна. Мэдээлэл өнөөдөр арилжааны нэг нэгж болж, ёс суртахуун, ёс зүй, нийгмийн үр нөлөөнөөс илүү эрэлт хэрэгцээтэй байна” хэмээн үзэв. Үнэхээр мэдээллийн хувь нэмрийг үнэнээр тодорхойлохын тулд энэ зууны технологийн гайхамшиг болох гадаад талын олон өөрчлөлтөөс илүү үр нөлөөний дотоод чанарт анхаарлаа хандуулах нь чухал юм. Өөрөөр хэлбэл глобальчлалын эрин үед хэвлэл мэдээллийг ямар байлгахыг мэргэжлийн хүмүүс өөрөө өөрсдөөсөө асуух цаг болжээ.

Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхэн түүхэнд гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа ухамсарлах цаг үе тулгарч байна.

Юуны тулд хүн төрөлхтөн бүхэл зууны туршид хэвлэлийн эрх чөлөө гэгчийн төлөө тэмцэлдэв?

Хүн төрөлхтөн зөвхөн өөрийнхөө төлөө тэмцжээ. Өөрт нь цор ганц заяасан дотоод итгэл үнэмшлийнхээ илрэл үзэл бодлынхоо төлөө тэмцэж.

Хэвлэлийн эрх чөлөө бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө юм. Хэвлэлийн эрх чөлөө бол хүний оршин буй

нийгэм, амьдарч буй дэлхийнхээ тухай мэдээлэл авах эрх, түгээх эрх чөлөө юм. Хүний эрхийн Америк дундын шүүх "Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлдэг" хэмээн тэмдэглэв. Мөн Хүний эрхийн Европын шүүх "Хэвлэлийн эрх чөлөө нь олон нийтэд шинэ санаа сэдэх, улс төрийн удирдагчдын тухай болон хувийнх нь үзэл бодлыг бүрэлдүүлэн тогтоох замаар хамгийн сайн сайхан боломжийг олгодог.

Ялангуяа улс төрчдөд олон нийтийн санааг зовоож буй асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, тайлбарлах боломж олгоно. Энэ нь хүн бүрт ардчилсан нийгмийн тухай ойлголтын гол сэгжмийн талаарх улс төрийн чөлөөт маргаанд оролцох бололцоог бас олгоно" гэжээ.

Чөлөөт хэвлэл гэдэг бол бүхэлдээ чөлөөт ард түмэн юм. Энэ бол төгс ухагдхуун. Хүн төрөлхтөн чөлөөт хэвлэлийн төлөө тэмцэх замдаа олон үр дүнд хүрсэний нэг нь мэдээлэл технологийн дэвшил буюу Интернет юм. Интернет хүн бүрийг хэвлэн нийтлэгч болгож байна. Магадгүй хүн төрөлхтөн үзэл бодлынхоо хэтэрхий өргөн эрх чөлөөнд өөрсдөө живж байж болох юм. Тэгэхээр хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн эдлэх вэ гэдэг асуудал зарим өндөр хөгжилтэй оронд хэлэлцэх асуудлын нэг болж байж ч болох.

Тэгвэл дэлхийн улс орнуудын тасархай, Азид ардчиллыг анх цогцлоосон Монгол оронд хэвлэл мэдээллийн чөлөөт байдал ямар байна вэ? Монголчууд хэвлэлийн эрх чөлөөний төлөө хэрхэн тэмцэв?

Монгол орны хувьд хэвлэл мэдээллийн либеральчлалыг гол болгосны түүхэн баримт нь 1990 оны эхээр өрнөсөн ардчилсан хувьсгал хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэж байснаар баталгааждаг юм. Тэрхүү тэмцлийн зорилго ч биелэгдсэн билээ.

Төрийн цензур устав. Хүмүүс сонин хэвлэл эрхлэн гаргах эрхээ дураар эдлэв. Хүмүүс юу хүссэнээ бичиж, юу хүссэнээ ярьдаг болов. Нэг нэгнийхээ хувийн амьдралд хүртэл хошуу дүрцгээх болов.

Монголчууд хэвлэлийн үерт автагдаа. Төрийн өмчин дээр суусан "архаг" хэвлэлүүд арай нэг буурь зааж, хөнжил орны явдал бичихээс "ичиж" байв.

Төр өдөр тутам өөрийнхөө үйл ажиллагааг магтуулж, үндэстэн даяар хүчээр тараадаг хэвлэлтэй байгаа цагт хэвлэлийн эрх чөлөө гэж Монголд байна уу? Төр хэвлэлтэй байх ёстой! Төр хэвлэлтэй байх ёсгүй! Нийгэмд ийм маргаан дэгдэв. 1994 оны улс төрийн өлсгөлөнгөөр төр хэвлэлийг өмчлөхөө зогсоохыг шаардав. П.Очирбатын, Т.Гандийн зэрэг хэд хэдэн хуулийн төсөл боловсрогдов. Эдгээр нь хууль тогтоогч-

«
*Монгол орны хувьд хэвлэл
мэдээллийн либеральчлалыг
гол болгосны түүхэн баримт
нь 1990 оны эхээр өрнөсөн
ардчилсан хувьсгал
хэвлэлийн эрх чөлөөний
төлөө тэмцэж байснаар
баталгааждаг юм.*
»

дын дунд хэд хэдэн удаа яригдсан ч тухайн үеийн маргаантай байдлаас шалтгаалж УИХ-аар батлагдаж чадсангүй. Хэвлэлийн эрх чөлөөний төлөө байдаг мэргэжлийн байгууллагууд тухайлбал Монголын Чөлөөт Ардчилсан Сэтгүүлчдийн Эвлэл Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоотой хамтран хэрэгжүүлсэн "Ардчиллын төлөөх хэвлэл мэдээлэл" төслийн хүрээнд мэргэжилтнүүд авчирч хуулийн төслүүдэд шинжилгээ хийлгэв. Шинжээчид Засгийн газарт хандан "хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах хууль эрх зүйн болон практик үйл ажиллагааг олон улсын хэм хэмжээнд явуулах нь зүйтэй. 1996 оны сонгуулийн үр дүнд бий болсон шинэ парламент Монголын хууль тогтоомжуудад өөрчлөлт хийхдээ хараат бус шинжээчдээс бүрдсэн комисс байгуулан одоо үйлчилж буй болон шинэ хуулийн төслийг нягтлан үзэж, олон улсын хэм хэмжээнд тулгуурласан зөвлөмж гаргах нь зүйтэй болов уу" хэмээн зөвлөсөн байна. Мөн шинжээчид МЧАСЭ болон хэвлэл мэдээллийн бусад байгууллага, төрийн бус байгууллагууд хэвлэлийн эрх чөлөөг хангах, хамгаалах үйлсээ үргэлжлүүлэх нь зүйтэй. Ялангуяа сэтгүүлчийн мэргэжлийн эрх, ур чадварын талаарх олон улсын хэм хэмжээг баримталж, энэ тухай Засгийн газарт мэдээлэл өгч байхыг зөвлөжээ.

1999 онд хэвлэл мэдээллийн орчинд өөрчлөлт гарав. Төр хэвлэл мэдээллийн талаарх хоёр дахь зохицуулалтаа хийлээ. Нийгмээрээ ардчилсан тогтолцоог хүлээн зөвшөөрснөөс хойш арав орчим жилийн дараа УИХ-аар "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" Монгол улсын хуулийг

батлан гаргав. Энэ бол Монголын чөлөөт хэвлэлийн түүхэнд хэвлэлийн эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан чухал үйл явдал болсон юм. Энэхүү хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршжээ. Мөн төрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад цагдан хяналт тогтоохыг хориглов. Мөн хяналтын байгууллага байгуулах болон санхүүжүүлэхийг хязгаарлав. Төрийн байгууллага дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг ч хуулиар хориглолоо. Үүний хажуугаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийн нийтлэлийнхээ төлөө хариуцлага хүлээж байхыг хуульчилж өгөв. Энэ бүхэн хэвлэл мэдээллийн хуулийн ач холбогдолыг тодорхойлж байгаа юм. Төр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөхөөс татгалзсан нь энэхүү хуулийн нэр төрийг өргөсөн билээ.

Харин хэвлэл мэдээллийнхэн хуультай болж байх үед чөлөөт хэвлэлийн орчинд:

– Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хүний эрх чөлөө, ялангуяа хувийн нууц руу хэт өнгийх хандлага газар авсан.

– Баримтыг нягталж, шалгаагүйгээс шүүхийн өмнө буруудаж, санхүүгийн болон нэр хүндийн "торгууль" хүлээх явдал олширсон.

– Олон түмний чөлөөт сонин хэвлэлд итгэх итгэл буурч, улмаар энэ нь сонин хэвлэлийн бизнест нөлөөлсөн.

– Төр засгийн зүгээс өөрийн мэдлийн сонин хэвлэлийг илүүтэй дэмжих болсон зэрэг нөхцөл байдлууд бодитой оршиж байв.

Хэвлэл мэдээллийн орчин дахь энэхүү нөхцөл байдал нь хэвлэлийн хуулийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхэд сэтгүүлчдэд таатай боломжийг өгч чадаагүй юм. Харин улс төрчдөд илүү аятай боломжийг олгосон гэхэд хилсдэхгүй.

Хэвлэлийн хуультай болсноор чөлөөт хэвлэл бололцоог үнэхээр ашигласан уу? Бололцоог ашиглуулсан уу?

Улс төрчид сонин хэвлэлийн нийтлэл мэдээлэлдээ гаргах болсон алдаа, олон түмний нийтлэл мэдээлэлд итгэл буурах хандлагыг овжиноор ашиглалаа. Тэд үндэсний хэмжээнд нийтлэл мэдээлэл нь түгээн тараагддаг, өдөр тутмын сонины төрийн өмчийг задлахдаа хувьцааг нь өөрсөддөө ашигтайгаар төвлөрүүлж амжив. Хэдийгээр чөлөөт хэвлэлийнхэн “өрсөлдөөний тэгш гараа” хэмээх зөв байж болох хувилбарыг дэвшүүлж, төрийн мэдлийн сонины хувьцаанаас эзэмших ёстой хэмээн тэмцэж байсан боловч амжилтанд хүрч чадаагүй юм. Хэвлэлийн хууль ёсоор “Ардын эрх” “Өдрийн сонин”, “Засгийн газрын мэдээ” “Зууны мэдээ” нэртэй болов. Өдөр тутам хэвлэгдэж, үндэсний хэмжээнд тараагдах чанараараа

хүчирхэг хэвээр байгаа өдөр тутмын сонины ард улс төрчид, түүний бүлэглэл хувьцааг нь эзэмшин нууц эзнээр сууцгаасан юм. Ийнхүү өдөр тутмын сонин төрийн хяналтаас мултарч, улс төрчдийн гарт хялбархан орчихлоо. Тэд өнөөдөр нийтлэлийнх нь бодлогод хяналт тавьж, өөрсдийнхөө улс төрийн тэмцлийн зэвсэг болгон ашиглаж байна. Үүний баталгаа нь сонины хуудаснаа хэвлэгдэж буй нийтлэл мэдээллийн ерөнхий чиг хандлага нь.

Өдөр тутмын сонины хувьчлалын дараа чөлөөт хэвлэлүүдийн эзний өмнө “хэрхэн дампуурахгүй байх вэ” гэсэн асуудал тулгарч ирэв. Тэд хэрэглэгчдийн эдийн засгийн сонирхол дээр тулгуурлан сониноо борлуулах янз бүрийн арга хайж сүвэгчлэв. Тэр нь ч амжилттай болж, улмаар чөлөөт

«

Сонины эзэд эрх мэдэлтнүүдтэй туйлын болгоомжтой бас “хайр зарласан” байдлаар харьцах болов. Олон арван мянган захиалагчтай болсон сонины эзэд улс төрчидтэй түншилж, зарим нь сонгуульд ялсан намаас албан тушаал ч сонсох болов.

»

сонины өрсөлдөөнд хэд хэдэн сонин байр сууриа эзэлж авлаа. Харамсалтай нь үүний цаана ёс суртахуунтай, хариуцлагатай сэтгүүл зүй орхигдож байлаа. Сонины эзэд эрх мэдэлтнүүдтэй туйлын болгоомжтой бас “хайр зарласан” байдлаар харьцах болов. Олон арван мянган захиалагчтай болсон сонины эзэд улс төрчидтэй түншилж, зарим нь сонгуульд ялсан намаас албан тушаал ч сонсох болов. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын түшмэд, хэвлэл мэдээллийн эзэмшигч хоорондын тохиролцоо хүчтэй болж эхлэв.

Мөн улс төрчдийн зэрэгцээ сонин хэвлэлд санхүүгийн бүлэглэл нөлөөгөө чиглүүлж эхэллээ. Хэвлэл эзэмшигч нь зар сурталчилгаа өгөгч, санхүүгээр дэмжигч тэйгээ "түншлэх болов". Сонин хэвлэл-лийн нийтлэл сонирхлын бүлгийн эх сурвалжаас ихээхэн хамаарах болов. Ийнхүү улс төр болон санхүүгийн бүлэглэлээс хараат байдал нь хэвлэлийн гол бүтээгдхүүн болох мэдээ мэдээлэл сонины эзнээсээ хамааралтай болж, улмаар чөлөөт хэвлэлийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь алдагдахад хүргэсэн юм. Эндээс дүгнэхэд хэвлэл мэдээллийн хуультай болсноор чөлөөт хэвлэл хөгжих бололцоогоо ашигласан уу? Эсвэл бололцоогоо ашиг-луулсан уу? хэмээн асуусны хариулт нь ашиглуулсан гэсэн үгээр илүү илэрч, энэ нь нөлөө бүхий хэвлэлүүд эргээд улс төр, санхүүгийн бүлэглэлүүдийн хараат болсноор улам баталгаажиж байна. Бүр тодруулбал, өнөөдөр Монголын томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ихэнхдээ улс төрийн капитал буюу улс төрийн хүчин, бүлэглэлийн гар хөл болсон аястай хөгжиж байна. Энэ байдал нь Монголын чөлөөт хэвлэлийг өнөөдөр ардчиллын жинхэнэ тулгуур багана нь болж байна гэж үзэхэд ч эргэлзэхэд хүргэж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон түмнийг тэдний ашиг сонирхолд нийцсэн, үнэн бодит мэдээллээр хангах үүрэгтэй ажилладаг. Энэ үүргийг нь олон улсын хуулинд Европын Хүний эрхийн Шүүхийн онцлон тэмдэглэснээр хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хэвлэл мэдээлэлд мэдээлэл болон олон нийтийн ашиг сонирхлын талаарх санаа бодлыг хуваарилах үүрэг ноогдоно. Олон нийт ч тэдгээр мэдээлэл, санаа бодлыг хүлээн авах эрхтэй. Хэрэв энэ үүрэг, эрх зохицолдохгүй бол хэвлэл мэдээлэл нь "ард түмний хоточ нохой" байх амин чухал үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ.

Хэвлэл мэдээлэл олон түмнийг мэдээллээр хангах үүргээ биелүүлэхэд нь Засгийн газар туслах ёстой. Засгийн газар ийнхүү гар сунгаснаар олон түмнийг мэдээллээр хангах төрийн үүргээ давхар гүйцэтгэж байгаа юм. Засгийн газар олон улсын хуулийн дагуу хүлээн зөвшөөрсөн хэвлэлийн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах үүргээ гүйцэтгэх явцдаа Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Үндсэн хуулиар олгогдсон хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг нь давхар хүндэтгэж байгаа хэрэг юм. Гэхдээ Засгийн газрын энэхүү хүндэтгэл нь хараат бус, олон ургальч хэвлэл мэдээлэл цэцэглэн хөгжихэд ямар бодитой дэмжлэг үзүүлснээр илүү хэмжигдэнэ.

Монголын өнөөгийн төр засаг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэхэд санаа тавихгүй, харин ч хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байна. Энэ шүүмжлэл нь хууль батлан гаргасан Ардчилсан холбоо эвслийн Засгийн газарт ч нэгэн адил хамаатай. Нийтлэл, нэвтрүүлэг нь үндэсний хэмжээнд түгэн тардаг, мэдээллийн хүчирхэг хэрэгсэл болох радио, телевиз эдүгээ хүртэл төр засгийн мэдэлд байна. Хэвлэлийн хууль гарахаас өмнө, хойно

олон нийтийн радио, телевизийн тухай хэд хэдэн хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан ч хэлэлцэгдэн батлагдсангүй. МРТХЭГ нь Засгийн газрын агентлагийн статустай хэвээр, төрийн төвлөрсөн төсвөөс санхүүждэг, удирдлагыг нь Засгийн газраас томилдог, Засгийн газрын "даалгаврыг биелүүлдэг" хуучин механизм хэвээр байна. Радио, телевиз ийнхүү төрийн мэдэлд байгаа нь олон түмнийг тэнцвэртэй, хүсэн хүлээсэн мэдээллээр хангах бус, харин эрх барьж буй нам, хүчинд илүүтэй үйлчлэх бололцоог бий болгож байна. Тэнд хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, олон ургальч үзэл хязгаарлагдмал байна. Засгийн эрхийг барьж байгаа улс төрийн хүчин өөрөө шууд, эсвэл томилсон удирдлагуудаар

нь дамжуулан нэвтрүүлэг болон ялангуяа цаг үеийн мэдээний агуулгад нөлөөлж, зарим тохиолдолд бүр хутгалдан орж, үзэл бодлоо хэт тулган тэнд ажиллагсдад дарамт үзүүлдэг. Энэ тухай сэтгүүлчид албан бус ч амин хувиар гомдолдог юм. Тэр нь сэтгүүлч мэргэжлээ, сэтгүүлчийн бүтээлээ хамгаалсан хэрэг. Ийнхүү эрх баригчдаас хэт хараат байгаа нь Үндэсний радио телевиз төрийн өмчин дээр оршин тогтнож, түүний шат, шатны удирдлагыг Засгийн газраас томилдогтой шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл, хэвлэл

мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн тухай асуудлыг Хэвлэлийн эрх чөлөөний хуультай нийцүүлэн өөрчлөөгүйн уршиг өнөөдөр олон түмний тэнцвэртэй, үнэн бодит мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь хохироож байна. Хэрвээ тухайн мэдээллийн хэрэгсэл хувийн өмчин дээр тулгуурлан ажилладаг бол улс төрчид ийм эрээ цээргүй зан гаргахгүй бөгөөд харин ч сэтгүүлчдэд хүндэтгэлтэй хандаж, мэдээлэл өгдөг нь дэлхийн практикаас харагддаг зүйл билээ.

Гэхдээ өнөөдөр радио, телевизийн сэтгүүлчдийн дунд нэгэн болгоомжлол үүсчээ. Энэ нь төрийн өмчийг хувьчлах нэрээр хэсэг бүлэг хүмүүс завшиж, үндэсний хэмжээний мэдээллийн хэрэгсэл эргээд хэсэг улс төрчдийн түүний цаадах улс төрийн хүчний "зэвсэг" болчих вий

гэдэг болгоомжлол юм. Сонин хэвлэлийг хувьчилсан гашуун туршлага радио, телевиз дээр давтагдахгүй гэхийн аргагүй.

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гарснаас хойш зайлшгүй хийх ёстой тус хуулийн зүйл заалттай зөрчилдсөн бусад эрх зүйн актыг хүчингүй болгох, өөрчлөх шийдвэр өнөөг хүртэл гарсангүй.

Чөлөөт хэвлэл мэдээлэл өнөөдөр иймэрхүү байдлаар төлөвшиж байгаа нь бидний сонгож авсан ардчилсан тогтолцоо улам батжиж, ардчилсан нийгмийн

«
Хэрвээ тухайн мэдээллийн хэрэгсэл хувийн өмч дээр тулгуурлан ажилладаг бол улс төрчид ийм эрээ цээргүй зан гаргахгүй бөгөөд харин ч сэтгүүлчдэд хүндэтгэлтэй хандаж, мэдээлэл өгдөг нь дэлхийн практикаас харагддаг зүйл билээ.

»

төлөвшилтөнд тэдгээрийн гүйцэтгэх үүрэг ээдрээтэй, бас эргэлзээтэй болж байна.

Дээр өгүүлсэн бүхнийг эргэн нэгтгэн дүгнэе. Хэвлэл чөлөөтэй байж либеральчлагдахын гол утга учир нь үзэл бодлын чөлөөт өрсөлдөөн, нийгмийг ардчилах гол нөхцөл, дөрөв дэх эрх мэдэл (Хууль тогтоох, гүйцэтгэх, мөн шүүх засаглалыг олон түмний өмнөөс хянаж байх), хүмүүсийн хэвлэн нийтлэх нээлттэй эрхийн баталгаа нь болж чаддагт оршдог юм.

Үзэл бодлын чөлөөт өрсөлдөөнийг Монголын мэдээллийн зах зээл дээр сонин хэвлэлүүд олноор "үйлдвэр-лэгдэж", сэтгүүлчид болон хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсноор тайлбарлахаас илүүтэйгээр чөлөөт хэвлэлүүд өрсөлдөөний явцад олон түмний болон нийгмийн эрх ашигт үйлчлэх үндсэн үүргээсээ хазайж, хувь хүний эрх чөлөө, нэр хүндэд илүүтэй "анхаарч", хүмүүсийн хувийн амьдралаар бизнес хийх болсон өрсөлдөөнөөр илүү үнэлэгдэж иржээ.

Чөлөөт хэвлэл бол нийгмийг ардчилах гол нөхцөл нь юм. Хүний мэдээлэл олж авах, түүнийгээ боловсруулах, үгээ хэлэх, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, нийгмээ хянах тэрхүү боломж нь гагцхүү чөлөөт хэвлэлээр дамжин илүү бодитой хэрэгждэг. Нөгөө талаар ил тод байдлыг эрхэмлэдэг, ухаалаг, ээлтэй удирдлагад урам дэм өгч, улмаар нийгэмд хууль ёс, дэг журам, жинхэнэ шударга байдал биеллээ олоход нь тусалдаг. Монголын хэвлэл мэдээлэл нийгмийг ардчилахад, улс төрчид, албан тушаалтныг өөрийн үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх чадвартай болоход нь нөлөөлөх учиртай.

Гэвч нөлөө бүхий хэвлэлүүд тодорхой улс төр, санхүүгйн бүлэглэлд илүүтэй үйлчлэх хандлага давамгайлж байна.

Чөлөөт хэвлэл бол хууль тогтоох, гүйцэтгэх, мөн шүүх засаглалыг олон түмний өмнөөс хянаж байх утгаараа нийгэмд дөрөв дэх эрх мэдэл хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Хэдийгээр тус тусдаа ялгаатай ч нийтлэг талаас нь харвал сонин хэвлэл эрх мэдэлтэн, тодорхой нөлөө бүхий албан тушаалтны нэр сүр, албан тушаалаа ашигласан үйлдэлд "хяналт" тавьж, улмаар нийтэлж мэдээлж, ямар нэгэн хэмжээгээр олны анхаарлыг түүнд чиглүүлж байна. Үүний тодорхой нэг жишээ нь "казиногийн хэрэг" хэмээн нийтэд алдаршсан УИХ-ын гурван гишүүний авилгалд холбогдсон тухай мэдээллийг сэтгүүлчид л анх мэдээлж, хуулийнхний анхаарлыг түүнд хандуулсан юм. Гэвч эрх зүйн болон бусад олон зохицуулалт дутуу буюу огт хийгдээгүйгээс өнөөдөр хэвлэл мэдээлэл хагас эрх чөлөөтэй байдлын дор хянах үүргээ илүү хориглолтын байдалтай гүйцэтгэж байна. Энэ нь зах зээлийн өрсөлдөөнд ялагдал хүлээхээс эмээсний буюу тэдний бизнес сонирхол хэт давамгайлсны илрэл ч байж болох.

Чөлөөт хэвлэл бол хэвлэн нийтлэх нээлттэй эрхийн баталгаа юм. Энэ нь хүн бүр үгээ хэлэх, нийтлэх, улмаар сонин хэвлэл эрхлэн гаргах бололцоог бий болгосноор илэрдэг. Төрийн цензурыг халсны дараахан Монголд сонин хэвлэл борооны дараах мөөг шиг олширч, нэг эзний нэр дор ч нийтлэлийн чиг хандлагаараа эрс ялгаатай хэд хэдэн сонин

хэвлэгдэх болсон юм. Харин сүүлийн үеийн хандлагаас харахад мэдээллийн зах зээл дээр шинэ сонин хэвлэл үзэгдэх нь ховордож байна. Хэвлэлийн Хүрээлэнгийн Мониторингийн дөрвөн жилийн судалгаагаар 170 орчим сонин хэвлэл, телевиз 27 кабель 11, 35 радио тогтвортой ажиллаж байна. Гэхдээ хаагдсан, нэмэгдсэн сонин хэвлэлийн тоон хэлбэлзлэл 170 орчимд л эргэлдэж байна. Нэгэн сонин гэмээр үзэгдэл байгаа нь сонины эзэд тодорхой компани, хувь хүн, бүлэглэлд сониныхоо эрхийг худалдах хандлага цөөнгүй гарах болжээ.

Мөн үүний зэрэгцээгээр чөлөөт хэвлэл бүхий Монгол оронд цензур байна уу? гэсэн сонирхолтой асуулт аяндаа урган гарч ирдэг.

Цензур байвал нөгөө талд нь хүний эрх зөрчигдөж байна гэсэн үг. Цензурыг бий болгохгүйн тулд түүнийг хориглосон хуультай байх нь зайлшгүй. Ингэж хэвлэлийн эрх чөлөөг эрхэмлэгч орнууд үздэг.

“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” Монгол улсын хуулиар мэдээлэлд цагдан хяналт тавихыг хориглов. Энэ нь “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй”,

“Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт хэрэгжүүлэх байгууллага байгуулах, хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” хэмээх хуулийн заалтаар баталгаажив. Харин хууль, түүний хэрэгжилт бодит байдал дээр зөрүүтэй байна. Хуулиа хэрэгжүүлэх эсэх нь төр засгийн өөрийнх

нь улс төрийн хүсэл зоригийн илэрхийлэл болжээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол Улсын Их Хурал МРТХЭГ, МонЦаМэ агентлагийг Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд татан буулгаж, үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон зохион байгуулах тухай тогтоолыг баталсан боловч хоёулаа Засгийн газрын агентлагын статустай хэвээр байна. Түүний удирдлагыг Засгийн газраас томилж, төсвөөс санхүүжүүлж байна.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд олон түмэнд үйлчлэх статустайгаар ИТХ-ын харьяанд очсон боловч хэрэг дээрээ нийслэл, аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газрын хараа, хяналтад ажилладаг хуучин тогтолцоо хүчтэй хадгалагдаж байна. Төрийн зарим институтууд ч өөрийн харьяаны хэвлэл, сонин эрхлэн гаргаж байна. Төрийн өмчин дээр байгаа, улсын төсвөөс татаас авдаг, удирдлагыг нь томилдог байдал нь эргээд нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад шууд болон дамжуулан тавих хяналтыг хүлээн зөвшөөрөхөд хүргэж байгаа юм. Уг нь эзэмших, хянах гэдэг нь хоёр тусдаа асуудал, хоёр өөр ойлголт. Төр радио телевизийн өмчийг эзэмшиж болно. Энэ нь “бүтээгдэхүүнийг” нь хянана гэсэн үг биш. Мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлж хянах нь олон ургальч үзэлд харш зүйл. Энэ нь хүмүүсийн өөрийн дотоод итгэл үнэмшилдээ тулгуурласан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлана.

Хүмүүсийн нийгмийн идэвхтэй гишүүн байж, сонгосон төр засгийнхаа үйл ажиллагаанд үгээ хэлэх, улмаар тэднийг хянах үүрэгт нь саад тотгор болно.

Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн нь төрийн дарамтаас илүү шахалтыг хэвлэл мэдээлэлд авчирчээ. "Юу бичихийг зах зээл мэднэ, яаж бичихийг эзэн мэднэ" гэсэн Өрнөдийн зарим орны зарчим Монголын хэвлэлд хүчтэй үйлчилж байна. Энэ зарчмаас гажвал зах зээлийн хуулиар оногдох ганцхан гарц бий, тэр нь дампуурал юм. Дампууралд хүрэхгүйн тулд тухайн хэвлэл мэдээлэлд эзний цензур хүчтэй үйлчилж байна. Эзний цаана байгаа улс төр, эдийн засгийн бүлэглэлийн сонирхолд харш зүйлийг бичиж нийтлэх эрх тухайн сэтгүүлчид байхгүй. Сэтгүүлч юу дуртайгаа бичдэг эрх чөлөө, мэргэжлийн эрх нь эзний хяналтаар хязгаарлагдаж байна.

Олон ургальч үзлийг хумихад эдийн засгийн шахалт ямар ч шууд цензурээс хүчтэй нөлөөлдөг. Зах зээл заримынх нь хувьд дэндүү үнэтэй ашиг сонирхлыг хөхүүлдэг. Энэ нь эцэстээ тухайн хэвлэлийн хүч чадал, эрх мэдлийг улс төрийн тэмцлийн дуу хоолой болгох зорилго агуулдаг. Өнөөдөр зарим хэвлэлд мэдээллийн эзнийг нь "барьцаалсан" улс төр, санхүүгийн хүчтэй хяналт нь үйлчилж байна.

Цензур нь сонин хэвлэлийг шалгах, Ц хаах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нарыг сүрдүүлэх, шоронд хорих, сэтгүүлчийн амь насыг бүрэлгэх зэрэг хэлбэрээр илэрдэг. 1990 оны ардчилсан тогтолцооноос хойш хэвлэл мэдээллийн хэрэгслийг Засгийн

газраас шалгасан явдал хэд хэдэн удаа гарсан байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гарснаас хойш буюу 2000 онд Хууль зүй, Дотоод хэргийн яам хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг шалгаж, гурван ч сониныг хаажээ.

Хуулийн элдэв хязгаарлалтаар хэвлэл мэдээллийг цагдан хянах явдал Монголд хүчтэй байна. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтанг бичсэн нийтлэл, мэдээллийнх нь төлөө Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг тоталитор нийгмийн үеийн цензур ч өнөөдөр хэвээр байна. Энэ нь 2002 онд УИХ-аар батлагдсан Эрүүгийн шинэ хуульд гүтгэлэгтэй холбогдсон заалтуудаа улам чангатган, "хэвлэл мэдээллээр тараагдсан" бол хэмээн онцлон зааснаар илүү баталгаажиж байна. Сэтгүүлчийг бичсэн хэвлүүлсэн нийтлэлийнх нь төлөө шоронд хорьж болох эрх зүйн акт гаргаж байгаа нь Монгол улс нэгдэн орсон олон улсын гэрээ, тунхаглалаа зөрчиж буй хэрэг юм. Өнгөрсөн онд сэтгүүлч Б.Хандолгор сонинд нийтэлсэн мэдээллийнхээ төлөө, "Үг" сонины эрхлэгчийн хувьд хариуцлага хүлээж, шоронд хоригдож, ял эдэлсэн нь сэтгүүлчдэд айдас, болгоомжлолыг төрүүлсэн. Хуулийн дарамт, айдас болгоомжлолын дунд ажиллаж байгаа сэтгүүлч хүн шударга бус, хариуцлагагүй үйл ажиллагааны мөрөөр мөшгиж, нийгмийг элдэв ялзрал, гажуудлаас хамгаалж байх үүргээ хэрхэн, яаж биелүүлэх нь ойлгомжтой. Сэтгүүлчдийг барьж хорих нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх мэргэжлийн эрхийг нь

боогдуулдагаараа дэлхийд хамгийн аюултай цензурт тооцогддог юм.

Сэтгүүлчийн айдас болгоомжлол бол хамгийн "харгис" цензур мөн. Энэ нь сэтгүүлч хүн өөрөө өөрийгөө хянах тухай ойлголт юм. Сэтгүүлч хүн эрх мэдэлтний албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг, элдэв хуйвалдааны зах сэжүүрээс барьж авсан ч дарамт, шахалтаас болгоомжилж, олон түмний хоточ нохой байх үүргээ өөрөөсөө зайлуулж, түүнийг нуун дарагдуулахад хүргэдэг тохиолдол манайд цөөнгүй байдаг. Энэ утгаараа сэтгүүлчийн айдас болгоомжлол бол сэтгүүлчийн баримтлах "чухал мэдээг нуун дарж болохгүй" гэсэн зарчмаа зөрчин, өөрийгөө хянан цагдаж байгаа үйлдэл юм.

Цензурын хэлбэр нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн дотоод үйл ажиллагаар бас илэрдэг. Хэвлэл мэдээллийн байгууллага, редакци тодорхой нэгэн шалтгаанаар төр засаг, улс төр, санхүү болон нийгмийн зүгээс дарамтад орохоос зайлсхийж, эсвэл өөрт нь зохисгүй гэж үзсэн аливаа нөлөөллөөс өөрсдийгөө урьдчилан хамгаалахын тулд дотоодын цензурыг бий болгодог.

Энэ мэтчилэн янз бүрийн хэлбэрээр илрэн гардаг цензур өнөөдөр Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд амь бөхтэй байна.

Дүгнэхэд, ер нь цензур байна гэдэг нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг юм.

Ишлэл

1. Чөлөөт хэвлэлийн Хартигаас.

2. "Монгол дахь хэвлэлийн эрх чөлөө". МЧАСЭ. 1996. УБ.
3. Д.Цэмбэл, До.Цэнджав. 2001. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол практикийн асуудал. УБ.
4. МХХ. Мониторингийн судалгаа. УБ. 2002.

Situation of Mongolian Press and Media Freedom

In 1999, a change has occurred in press and media environment. The State had made its second regulations on press and media. A decade ago since democracy was adopted by the society, the Parliament had adopted the "Press and media freedom"-the law of Mongolia. It was the important event that confirmed press freedom in the history of Mongolian free press. The objective of this law was to confirm rights of the citizen of Mongolia to express own views and Believes, right to speech and publishing stated in the Constitution of Mongolia. Also the state was prohibited to censure on ideas of publications and programs of mass press and media. Moreover, it was restricted to establish inspection organization and make financing. State organizations were forbidden to have press and media means according to law. Besides, it has legalized that press and media should be responsible for their publication and program. These are defining the importance and significance of press and media law. The dignity of this law was highlighted by the fact that state refused to own mass press and media.